

БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Я.АМАРЖАРГАЛ

НИЙЛҮҮЛЭГЧ

“АГЛАГМЕД” ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

С.Мөнхзул С.МӨНХЗУЛ

ВАКЦИНЫ ЗҮҮ ТАРИУР НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ №428

Дугаар № ЭМЯ/В/2020/03

Улаанбаатар хот

Нэг талаас [ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [Аглагмед ХХК] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 11 сарын 20-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

- Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- Захиалагч нь **Вакцины зүү тариур худалдан авах ЭМЯ/В/2020/03** (цаашид “бараа” гэх) тендерийн **Багц №1-ийн барааг нийт 17,708,350** /арван долоон сая долоон зуун найман мянга гурван зуун тавин/ төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) 2020 оны 12 дугаар сарын 25-ны дотор нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хүснэгт-1. Нийлүүлэх бараа

№	Барааны нэр төрөл	Үйлдвэрлэгч	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /НӨАТ орсон/	Нийт үнэ төгрөг
1.	AD-Syringe 0.5 ml (0.5 мл-ийн нэг удаагийн өөрөө эвдэрдэг тариур, зүүний хамт)	Sanavita Pharmaceuticals GmbH/ Wuxi Yushou Medical Appliances	ширхэг	110,000	160.985	17,708,350
Нийт дүн						17,708,350

- Захиалагч нь гэрээний үнэ **17,708,350** /арван долоон сая долоон зуун найман мянга гурван зуун тавин/ төгрөгийг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- Нийлүүлэгч нь нэг нэр төрлийн барааг 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
- Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх).
Үүнд:
 - Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - Бусад шаардлагатай баримт бичиг¹;
 - Үнийн санал;
 - Гэрээний тусгай нөхцөл;
 - Гэрээний ерөнхий нөхцөл;
 - Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
 - Санхүүжилтийн хуваарь.

Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нсхцэлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өсрөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

4. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
5. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хариуцлага хүлээнэ.
6. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факс хариуцана.
7. Захиалагч нь төрийн ашиг сонирхлыг дээдлэн, хувийн ашиг сонирлын үүднээс хууль бус үйлдэл гаргахгүй ажиллана.
8. Захиалагч нь төрийн алба, төрийн албан хаагчтай холбоотой стандартыг мөрдөж, төрийн албан хаагчийн ёс зүйн зүйн хэм хэмжээг сахина. Авлигаас ангид байж, авлигын эсрэг хууль тогтоомж дүрэм, журмыг мөрдөн ажиллана.
9. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад авлигын эсрэг хуульд заасан төр, байгууллага, албан хаагчийн хүлээсэн үүрэг зөрчигдөж байвал Авлигатай тэмцэх газарт мэдээлнэ.
10. Гүйцэтгэгч нь "гэрээ"-ний заалтуудыг зөрчиж, хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд захиалагч тал тухайн гүйцэтгэгчийн талаарх мэдээллийг "хар жагсаалт"-д оруулж олон нийтэд тод мэдээлнэ.

Хүснэгт-2 Санхүүжилтийн хуваарь

№	Багцын дугаар, барааны нэр	Гэрээний үнийн 50 хувьтай тэнцэх дүнг гэрээнд гарын үсэг зурснаас хойш 14 хоногийн дотор нийлүүлэгчийн гаргаж ирүүлэх нэхэмжлэхийг үндэслэн төлнө. (Захиалагчийн нэр, хаягийг бичиж, барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байна)	Гэрээний үнийн 50 хувьтай тэнцэх дүнг эм, эмэгтэйн хэрэгслийг хүлээлгэн өгөх хойш 14 хоногийн дотор нэхэмжлэх (Захиалагчийн нэр, хаягийг бичиж, барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт заасан, гарын үсэг, тэмдгээр баталгаажуулсан байна)
1	Багц 1, AD-Syringe 0.5 ml (0.5 мл-ийн нэг удаагийн өөрөө эвдэрдэг тариур, зүүний хамт)	8,854,175 /найман сая найман зуун тавин дөрвөн мянга нэг зуун далан таван төгрөг/	8,854,175 /найман сая найман зуун тавин дөрвөн мянга нэг зуун далан таван төгрөг/
	Нийт	17,708,350 / арван долоон сая долоон зуун найман мянга гурван таван төгрөг/	

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Нэр томъёо

Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- (а) "Гэрээ" гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд тохиролцсон нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгүүд бүрдэнэ.
- (б) "Гэрээний үнэ" гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн биелүүлэх хангалттай гүйцэтгэсний дагуу нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.
- (в) "Хоног" гэж хуанлийн хоногийг хэлнэ.

- (г) “Хүчинтэй болох хугацаа” Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр.
- (д) “Ашиглагч” Барааг хэрэглэх ГТН-д заагдсан эцсийн хэрэглэгчийг хэлнэ.
- (е) “ГЕН” Гэрээний Ерөнхий Нөхцөл.
- (ж) “Бараа” Гэрээний дагуу Захиалагчид нийлүүлэх бүх эм,эмнэлгийн хэрэгсэлийг хэлнэ.
- (з) “Захиалагч” гэж барааг худалдан авч буй гэрээний тусгай нөхцөлд нэрлэсэн байгууллагыг хэлнэ.
- (и) “Бүртгэлийн гэрчилгээ” хуулийн дагуу Монгол улсад бүртгэгдсэн гэрээгээр нийлүүлэх барааны гэрчилгээ.
- (к) “ГТН” Гэрээний Тусгай Нөхцөл.
- (л) “Үйлчилгээ” гэж тээвэрлэлт, даатгал болон бусад дагалдах үйлчилгээ, техникийн туслалцаа, сургалт зэрэг гэрээний дагуу нийлүүлэгчийн хариуцах үйлчилгээг хэлнэ.
- (м) “Байршил” ГТН-д заасан барааг хүргэх байршил.
- (н) “Нийлүүлэгч” ГТН-д заагдсан бараа болон үйлчилгээг гүйцэтгэх этгээдийг хэлнэ.

2. Үйлчлэх хүрээ

- 2.1 Энэ ерөнхий нөхцөлүүд нь гэрээний бусад хэсгийн заалтаас давуу үйлчлэхгүй.

3. Барааны гарал үүслийн улс

- 3.1 Гэрээний дагуу нийлүүлэх бараа нь тендерийн баримт бичигт тусгасан улсаас гарал үүсэлтэй байна.
- 3.2 Барааны гарал үүслийн улс гэдэгт барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн газрыг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.

4. Стандарт

- 4.1 Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь Техникийн тодорхойлолтод заагдсан стандартад нийцсэн байна. Тусгайлсан стандарт заагдаагүй тохиолдолд тухайн барааны гарал үүслийн улсын холбогдох стандартад нийцсэн байна. Энэ стандарт нь холбогдох байгууллагын хамгийн сүүлийн хүчин төгөлдөр хувилбар байна.

5. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах

- 5.1 Нийлүүлэгч нь захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд гэрээ ба түүний нөхцөл, эдгээртэй холбогдуулж захиалагчийн өгсөн техникийн тодорхойлолт, зураг, загвар, дээж зэрэг мэдээллийг гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтнаас бусад этгээдэд задлаж болохгүй. Гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтныг зөвхөн түүний хариуцсан ажилд шаардлагатай мэдээллээр хангана.
- 5.2 Захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд, нийлүүлэгч ГЕН-ийн 5.1-т дурдсан баримт бичиг болон мэдээллийг гэрээ гүйцэтгэхээс бусад зорилгоор ашиглахгүй.
- 5.3 ГЕН-ийн 5.1-т дурдсан гэрээнээс бусад баримт бичиг захиалагчийн өмч хэвээр үлдэх ба хэрэв захиалагч хүсвэл нийлүүлэгч гэрээний үүргээ гүйцэтгэж дуусмагц (бүх хувийг) захиалагчид буцааж өгнө.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

2. Тодорхойлолт (ГЕН-ийн Зүйл 1)

ГЕН 1.1 (и)	Захиалагч нь Эрүүл мэндийн яам.
ГЕН 1.1 (о)	Нийлүүлэгч нь АГЛАГМЕД ХХК
ГЕН 1.1 (н)	Байршил:
ГЕН 1.1 (е)	Ашиглагч байгууллага: Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв Дархлаажуулалтын алба

2. Үйлчлэх хүрээ (ГЕН-ийн Зүйл 2)

ГЕН 2	ГЕН-ийн 2-т хамаарах тусгай нөхцөл байхгүй
-------	--

3. Барааны гарал үүслийн улс (ГЕН-ийн Зүйл 3)

ГЕН 3	ГЕН-ийн 3-т хамаарах тусгай нөхцөл байхгүй
-------	--

4. Стандарт (ГЕН-ийн Зүйл 4)

ГЕН 4	ГЕН-ийн 4-т хамаарах тусгай нөхцөл байхгүй
-------	--

5. Гэрээний баримт бичгийг хэрэглэх (ГЕН-ийн Зүйл 5)

ГЕН 5	ГЕН-ийн 5-т хамаарах тусгай нөхцөл байхгүй
-------	--

6. Барааны бүртгэлийн гэрчилгээ (ГЕН-ийн Зүйл 6)

ГЕН 6.1 баримт	Монгол улсад импортлох шаардлагуудыг хангасныг нотлох бичиг
-------------------	---

7. Оюуны өмчийн эрх (ГЕН-ийн Зүйл 7)

ГЕН 7	ГЕН-ийн 7-д хамаарах тусгай нөхцөл байхгүй
-------	--

8. Гүйцэтгэлийн баталгаа (ГЕН-ийн Зүйл 8)

ГЕН 8.1	Гэрээний үнийн дүнгийн: 5%
---------	----------------------------

8. Шалгах болон турших (ГЕН-ийн Зүйл 9)

ГЕН 9.1	Шалгах болон туршихад тавигдах бусад шаардлагыг бичнэ.
---------	--

9. Баглаа боодол (ГЕН-ийн Зүйл 10)

ГЕН 10.2	Нэмэлт шаардлагууд нь Техникийн тодорхойлолтод тусгагдсан
----------	---

10. Барааны нийлүүлэлт болон баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН-ийн Зүйл 11)

ГЕН 11.1	Жишиг заалтууд (CIP нөхцөл) Монгол улсын гаднаас нийлүүлэх барааны хувьд: Нийлүүлэгч барааг тээврийн хэрэгсэлд ачсан даруй энэ бүрэн мэдээллийг захиалагч болон даатгалын байгууллага бичгээр мэдэгдэнэ. Мэдэгдэлд гэрээний дугаар, барааны нэр, тоо ширхэг, ачсан боомтоос гарах огноо, тээврийн хэрэгслийн нэр, буулгах боомт
----------	---

Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах (ГЕН-ийн Зүйл 24)

ГЕН 24	ГЕН-ийн 24-т хамаарах тусгай нөхцөл байхгүй
25. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах (ГЕН-ийн Зүйл 25)	
ГЕН 25	ГЕН-ийн 25-т хамаарах тусгай нөхцөл байхгүй
26. Маргааныг шийдвэрлэх (ГЕН-ийн Зүйл 26)	
ГЕН 26	ГЕН-ийн 26-д хамаарах тусгай нөхцөл байхгүй
27. Гэрээнд ашиглах хэл (ГЕН-ийн Зүйл 27)	
ГЕН 27.1	Монгол хэл
28. Гэрээнд мөрдөх хууль(ГЕН-ийн Зүйл 28)	
ГЕН 28.1	Гэрээнд Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөнө
29. Мэдэгдэл (ГЕН-ийн Зүйл 29)	
ГЕН 29.1	Эрүүл мэндийн яам, Засгийн газрын 8 дугаар байр, Улаанбаатар, Олимпийн гудамж-2, утас 263786
30. Татвар, хураамж (ГЕН-ийн Зүйл 30)	
ГЕН 30	Монгол улсын нутаг дэвсгэрийн гаднаас болон дотоодоос нийлүүлэгч зүү тариурыг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн ХӨСҮТ-д буюу эцсийн цэгт захиалагчид хүргэх хэрэгсэл оногдуулсан бүх татвар хураамж, тээвэр, даатгал болон бусад зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЭМЯ-ны Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Д.Нарантуяа

ЭМЯ-ны Эдийн засаг, санхүүгийн хэлтсийн дарга Т.Хонгорзул

ЭМЯ-ны Олон нийттэй харилцах, тандалт, шуурхай удирдлагын хэлтсийн дарга Д.Нарангэрэл

ЭМЯ-ны Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Д.Мөнхцэцэг

ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын албаны дарга О.Дашпагма

ЭМЯ-ны ТЗУГ-ын нярав, Зохион байгуулагч П. Энхболор

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ

"Аглагмед" ХХК –ийн Ерөнхий менежер /С.Сэргэлэн

Хаяг:
Хаяг: Эрүүл мэндийн яам, Засгийн газрын 8 дугаар байр, 3 давхар 306, тоот өрөө
Утас/Факс:

МОНГОЛ УЛСЫН ГАДИНА ҮНДЭВЭРЛЭГДСЭН БОГГОД ИМГӨР 100Р ОУЖ МЭЭЖ
БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ

ННТ-ын дугаар: